

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХӨВСГӨЛ ЭРЧИМ ХҮЧ ХХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: ХӨА-2023/09/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа
Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com
Аудитор Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuyats@gmail.com
Аудитор Б.Нэргүй
Утас: 99010744 Цахим хаяг: nerguib82@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	9
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

АДЗ.ДЗ.15 № 01/074
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ ЭРЧИМ ХҮЧ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ З.БАДРАЛ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолоор 2022 оны тайлант оны нийт орлогыг 12,704.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 13,191.6 сая төгрөгөөр, 486.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан ба ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тогтоолоор компанийн орлого, зардлыг 36.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 13,564,4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 14,816.1 сая төгрөгийн зардал гарган, 1,251.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тайлант оны алдагдлын 85 хувийг хэрэглэгчдэд борлуулахаар түгээлтэнд худалдаж авсан цахилгаан эрчим хүчний өртөг эзэлж байгаа бол үлдсэн 15 хувь нь бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт, компанийн үйл ажиллагаанаас шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 259.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 11.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 238.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 10.5 сая төгрөгийн 4 зөвлөмжийг өгч ажиллалаа.

Бусад асуудлын хэсэг

Их засвар, хөрөнгө оруулалт, ТЗБАХ-ийн арга хэмжээний төлөвлөгөөнд 31 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 930.9 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 786.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, их засварын ажил хийсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	262,425,273.20	266,790,934.66
1.1.2	Дансны авлага	1,336,245,128.57	882,495,076.43
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	75,161,480.01	85,278,945.93
1.1.6	Бараа материал	393,795,811.58	459,635,355.51
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,067,627,693.36	1,694,200,312.53
1.2.1	Үндсэн хөрөнгө	29,150,925,797.97	28,833,172,399.50
1.2.2	Биет бус хөрөнгө	655,638,421.43	657,405,852.18
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	29,806,564,219.40	29,490,578,251.68
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	31,874,191,912.76	31,184,778,564.21
2.1.1.1	Дансны өглөг	1,415,604,235.18	1,984,608,966.11
2.1.1.6	Хүүгийн өглөг	7,323,385.38	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	41,524,502.71	42,160,156.76
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,464,452,123.27	2,026,769,122.87
2.1.2.1	Урт хугацаат зээл	1,008,466,164.46	1,008,466,164.46
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,008,466,164.46	1,008,466,164.46
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,472,918,287.73	3,035,235,287.33
2.3.1	Төрийн өмч	16,800,000,000.00	16,800,000,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,831,501,384.55	7,831,501,384.55
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	8,317,866,421.53	8,317,866,421.53
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-3,548,094,181.05	-4,799,824,529.20
2.3.11	Эздийн өмчийн дүн	29,401,273,625.03	28,149,543,276.88
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	31,874,191,912.76	31,184,778,564.21

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	12,572,822,876.00	13,307,103,605.04
2	Борлуулалтын өртөг	11,867,828,144.60	13,274,392,098.70
3	Нийт ашиг (алдагдал)	704,994,731.40	32,711,506.34
8	Бусад орлого	137,524,524.05	257,241,896.60
9	Борлуулалт, маркетингийн зардал	1,122,465,177.26	1,202,796,465.04
10	Ерөнхий ба удирдлагын зардал	90,384,542.63	130,384,083.31
12	Бусад зардал	120,481,095.23	204,547,061.71
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	-3,956,141.03
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-490,811,559.67	-1,251,730,348.15
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-490,811,559.67	-1,251,730,348.15
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-490,811,559.67	-1,251,730,348.15
24	Орлогын нийт дүн	-490,811,559.67	-1,251,730,348.15

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,255,808,949.05	-3,057,282,621.38	29,830,027,712.22
Залруулсан үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,255,808,949.05	-3,057,282,621.38	29,830,027,712.22
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	62,057,472.48	-	62,057,472.48
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-490,811,559.67	-490,811,559.67
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	7,831,501,384.55	-	-	7,831,501,384.55
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,317,866,421.53	-3,548,094,181.05	29,401,273,625.03
Залруулсан үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,317,866,421.53	-3,548,094,181.05	29,401,273,625.03
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-1,251,730,348.15	-1,251,730,348.15
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	7,831,501,384.55	-	-	7,831,501,384.55
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,317,866,421.53	-4,799,824,529.20	28,149,543,276.88

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант үеийн дүн	Өссөн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	12,455,860,759.53	12,455,860,759.53
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	12,416,266,574.79	12,416,266,574.79
1.1.6	Бусад мөнгөн орлого	39,594,184.74	39,594,184.74
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-12,212,945,374.89	-12,212,945,374.89
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-1,113,732,438.95	-1,113,732,438.95
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-529,939,913.81	-529,939,913.81
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-805,046,992.98	-805,046,992.98
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-8,917,436.93	-8,917,436.93
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-9,032,703,302.94	-9,032,703,302.94
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-14,166,548.78	-14,166,548.78
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-390,484,668.54	-390,484,668.54

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-10,083,171.00	-10,083,171.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-307,870,900.96	-307,870,900.96
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	242,915,384.64	242,915,384.64
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-238,549,723.18	-238,549,723.18
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-238,549,723.18	-238,549,723.18
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-238,549,723.18	-238,549,723.18
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,365,661.46	4,365,661.46
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	262,425,273.20	262,425,273.20
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	266,790,934.66	266,790,934.66

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх оны үзүүлэлт	2022 он			
				Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Биелэлт
1	Түгээлтэд авсан цахилгаан	мян.кВтц	69,489.3	65,636.0	74,851.7	9,215.7	114.0
2	Цахилгаан түгээлтийн алдагдал	мян.кВтц	11,560.6	10,764.3	12,275.6	1,511.3	114.0
		%	16.6	16.4%	16.4%	2.1%	100.0
3	Борлуулсан цахилгаан	мян.кВтц	57,932.8	54,871.7	62,576.1	7,704.4	114.0
4	Нийт орлого	сая.төг	12,710.3	12,741.2	13,553.2	812.0	106.4
	Борлуулалтын орлого	сая.төг	9,449.6	9,307.6	10,060.0	752.4	108.1
	Түгээх үйлчилгээний орлого	сая.төг	3,123.1	3,247.1	3,247.1	0.0	100.0
	Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	137.6	186.5	246.1	59.6	131.9
5	Нийт зардал	сая.төг	13,201.1	13,228.1	14,816.1	1,588.0	112.0
	Үйл ажиллагааны зардал	сая.төг	3,921.3	4,416.8	4,638.8	222.0	105.0
	Худалдан авсан цахилгаан эрчим хүчний өртөг	сая.төг	9,141.2	8,624.8	9,974.4	1,349.6	115.6
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая.төг	138.6	186.5	202.8	16.3	108.8
6	Нийт ашиг алдагдал	сая.төг	-490.8	486.9	1,262.9	776.0	259.4

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл эрчим хүч компани нь 1965 оны Сайд нарын Зөвлөлийн 154 дүгээр тогтоолоор 1966 онд анх байгуулагдсан ба 2002 онд Түлш, эрчим хүчний яам болон Хөвсгөл аймгийн ИТХ-ын шийдвэрээр Хөвсгөл эрчим хүч ХХК болж зохион байгуулагдсан, орон нутгийн өмчийн 100 хувийн эзэмшилтэй, өмчийн эзэн нь Хөвсгөл аймгийн ИТХ юм.

Тус компанийн зорилго нь хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээртасралтгүй, найдвартай хангахад оршино.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд үйл ажиллагааны чиглэлийг “цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, хуваарилах үйл ажиллагаа” гэж бүртгэсэн байх ба дараах үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг эзэмшдэг. Үүнд:

- Цахилгаан түгээх;
- Цахилгаанаар зохицуулалттай хангах;
- Цахилгаан импортлох;
- Цахилгаан эрчим хүчний 1 ба 3 фазын механик, импульсийн болон электрон тоолуур, гүйдлийн трансформатор засварлах, суурилуулах;

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Хөвсгөл эрчим хүч ХХК нь Монгол Улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай, Компанийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай хуулиуд болон Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, Нэгдсэн сүлжээний дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Холболтын журам зэрэг хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Тус компани нь Эрчим хүчний зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулахаас гадна тус хорооноос баталсан үнэ тарифыг мөрдөж ажиллан, хэрэгжилтийг тайлагнадаг байна.

Тайлант онд компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх дараах шийдвэрүүд гарсан байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 410 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2022 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар айл ерхийн цахилгааны төлбөрийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс дааж, энэ хугацаанаас хойш хэрэглэгчид өөрсдийн хэрэглэсэн цахилгаан, эрчим хүчний төлбөрийг хийсэн.
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 510 дугаар тогтоолоор аж ахуйн нэгжийн цахилгаан эрчим хүч хэрэглэх үнэ тарифыг 2022 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн өөрчлөн баталсан.

Компанийн эрх барих дээд байгууллага нь Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хурлын чөлөөт цагт эрх барих байгууллага нь компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл байна.

Компанийн ТУЗ нь 9 хүний бүрэлдэхүүнтэй, хараат бус 3 гишүүнтэй бөгөөд аймгийн ИТХ-ын 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 06 тоот тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн томилсны дотор төрийн төлөөлөл 2 гишүүн, хараат бус 2 гишүүн тус тус шинээр томилогдсон байна.

Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөнд ТУЗ-ийн даргын сард авах урамшууллын хэмжээг 0.5 сая төгрөг, ТУЗ-ийн гишүүдийн сард авах урамшууллын хэмжээг 0.4 сая төгрөг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалинг 1.0 сая төгрөгөөр тогтоосон байна.

Компанийн ТУЗ 2022 онд нийтдээ 7 удаа хуралдаж, компанийн гүйцэтгэх захиралтай 2021 онд байгуулсан контрактын гэрээний биелэлт, компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланг тус тус “Хангалттай” гэж дүгнэсэн ба компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, бүтэц, орон тоог шинэчлэн

баталсан байна. ТУЗ-өөс худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, бүтэц орон тоо, ТЗБАХ, их засварын ажилд тодотгол хийсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдсөн.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдаж гарсан.

Тайлант хугацаанд компанийн санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн дотоод хяналтын талаар: Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны А/11 дүгээр тушаалаар “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг шинэчлэн, 2022 онд хэрэгжүүлэх дотоод хяналтын төлөвлөгөөг баталсан байна.

Компанийн дотоод хяналтын ажилтан ажилтнуудын холбогдох хууль тогтоомж, ажлын байрны тодорхойлолтын дагуу хийж буй ажилд, архив, бичиг хэргийн хөтлөлт, диспетчер болон реле хамгаалалтын хэсэгт хяналт шалгалт хийснээс гадна сумдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 3-р шатны үзлэгүүдийг хийсэн байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтыг үр нөлөөтэй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2018 онд боловсруулсан бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон хэдий ч хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Хөвсгөл эрчим хүч ХХК нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 700.6 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	262.4	266.8	4.4
Авлага	1,411.4	967.8	-443.6
Бараа материал	393.8	459.6	65.8

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Үндсэн хөрөнгө	29,806.6	29,490.6	-316.0
Нийт хөрөнгө	31,874.2	31,184.8	-689.4
Богино хугацаат өр төлбөр	1,464.5	2,026.8	562.3
Урт хугацаат өр төлбөр	1,008.5	1,008.5	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	29,401.3	28,149.5	-1,251.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	31,874.2	31,184.8	-689.4

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, бараа материал, богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн бол авлага, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл нэмэгдсэн шалтгаан нь байгууллагын мөнгөн касс 4,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 443.6 сая төгрөгөөр буурахад нөлөөлсөн гол ажил гүйлгээ нь:

- Цар тахлаас үүдсэн эдийн засгийн хүндрэлийг сааруулах зорилгоор төрөөс төлбөрийг нь даасан айл өрх, аж ахуйн нэгжийн 2021 оны 12 дугаар сард хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний төлбөр 842.8 сая төгрөгийн авлага тайлант онд барагдсан.
- Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь, жинхэнэ хэрэгжилтийн зарчмын үндсэн дээр 12 дугаар сард хэрэглэгчийн цахилгаан, эрчим хүч хэрэглээний бичилт хийсэн өдрөөс хойш он дуусталх хугацааны хэрэглээг тооцож, 285.6 сая төгрөгийн нэхэмжлээгүй авлагыг бүртгэсэн.
- Аж ахуйн нэгжүүдээс авах цахилгаан эрчим хүчний авлагын дүнг өмнөх онтой харьцуулахад 113.5 сая төгрөгөөр буурсан.
- Төрөөс 2020 оны 12 сарын 1-ний өдрөөс 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх айл өрхийн хэрэглэсэн цахилгааны төлбөрийг даасан бөгөөд түүнээс хойших төлбөрийг иргэд өөрсдөө төлөх болсонтой холбоотойгоор 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх айл өрхөөс авах цахилгааны авлага 94.6 сая төгрөгөөр өссөн.
- Мөрөн сумын ЗДТГ, Хот тохижилт үйлчилгээний төв ХХК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр айл өрхийн цахилгааны төлбөртэй хамт хурааж байгаа хог хаягдлын хураамжийн авлага 41.8 сая төгрөгөөр нэмэгдсэн.
- Холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр айл өрх, аж ахуйн нэгжид үзүүлж байгаа тарифын хөнгөлөлтийн авлагын үлдэгдэл 34.8 сая төгрөгөөр өссөн зэрэг болно.

Авлага дансны үлдэгдэлд олон жил дамжсан, эзэн холбогдогч тодорхойгүй, найдваргүй авлага 15,0 сая төгрөг, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн 10.5 сая төгрөг, ухаалаг тоолуурын борлуулалттай холбоотой 26.6 сая төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

Бараа материал дансны үлдэгдэл 65.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь сэлбэг хэрэгсэл болон аваарын нөөц сэлбэгийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Тайлант онд нийт 1,426.7 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 1,288.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна. Компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны А/59, А/84 дүгээр тушаалаар ашиглалтын шаардлага хангахгүй болсон, цаашид ашиглах боломжгүй, эвдэрч гэмтсэн, ашиглалтын хугацаа дууссан 72.4 сая төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх онтой харьцуулахад 316.1 сая төгрөгөөр буурахад нөлөөлсөн ажил гүйлгээ нь тайлант үеийн элэгдлийн зардал байна

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх онтой харьцуулахад 562.3 сая төгрөгөөр өссөн нь диспетчерийн үндэсний төвд түгээлтэд худалдаж авсан цахилгаан эрчим хүчний төлбөрийг дутуу хийсэнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 2007 онд Сангийн яам, Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн хооронд байгуулсан OL-3503MOG-07 тоот дамжуулан зээлдүүлэх 1,008.5 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өглөг бүртгэлтэй, тайлант онд уг урт хугацаат зээлийн 2021, 2022 оны хүүгийн төлбөрт нийт 14.2 сая төгрөгийг төлсөн, үндсэн зээлийн төлбөрөөс төлөөгүй байна.

Эздийн өмч дансны өөрчлөлт 1,251.8 сая төгрөг нь тайлант үеийн алдагдлаас шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн тайлант онд батлагдсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгт-2-оор харуулав.

Хүснэгт 2 Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн 2022 оны зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх оны үзүүлэлт	2022 он			
				Зорилтот түвшин	Биелэлт	Өөрчлөлт	Биелэлтийн хувь
1	Түгээлтэд авсан цахилгаан	мян.кВтц	69,489.3	65,636.0	74,851.7	9,215.7	114.0
2	Цахилгаан түгээлтийн алдагдал	мян.кВтц	11,560.6	10,764.3	12,275.6	1,511.3	114.0
		%	16.6	16.4%	16.4%	2.1%	100.0
3	Борлуулсан цахилгаан	мян.кВтц	57,932.8	54,871.7	62,576.1	7,704.4	114.0
4	Нийт орлого	сая.төг	12,710.3	12,741.2	13,564.40	823.2	106.5
5	Нийт зардал	сая.төг	13,201.1	13,228.1	14,816.1	1,588.0	112.0
6	<u>Нийт ашиг алдагдал</u>	сая.төг	-490.8	486.9	1,251.7	764.8	257.1

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хөвсгөл эрчим хүч ХХК нь техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолоор 2022 оны тайлант оны нийт орлогыг 12,704.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 13,191.6 сая төгрөгөөр, 486.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар, их засвар, хөрөнгө оруулалт, ТЗБАХ-ын арга хэмжээнд 921.2 сая төгрөгийг баталсан байна.

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тогтоолоор компанийн орлого, зардлыг хог хаягдлын хураамжийн шимтгэлээс олсон орлого 36.5 сая төгрөгөөр, ТЗБАХ, их засварын ажлын төлөвлөгөөнд тодотгол оруулж, 930.9 сая төгрөг болгон тус тус нэмэгдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр 13,564.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 14,816.1 сая төгрөгийн зардал гарган, 1,251.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 13,564.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 823.2 сая төгрөг буюу 6.5 хувиар давахад хэрэглэгчийн тооны өсөлтөөс гадна хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдсэн дараах нөхцөл байдал нөлөөлжээ. Үүнд:

- Засгийн газрын шийдвэрээр 2020 оны 12 дугаар сараас эхлэн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүч хэрэглэсний төлбөрийг төрөөс даах болсонтой холбоотойгоор хэрэглэгчдийн хэрэглээ эрс нэмэгдсэн.
- Хөвсгөл аймагт шинээр орон сууцнууд ашиглалтад орсон, коронавирусын нөхцөл байдлын үед үйл ажиллагаа тодорхой хүрээнд хязгаарлагдаж байсан сургууль, цэцэрлэгүүд, бусад төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүд 2022 оноос хэвийн ажиллаж эхэлснээр хэрэглээ нэмэгдсэн.
- Эрчим хүчний зохицуулах хорооны шийдвэрээр 2022 оны 11 дүгээр сараас аж ахуйн нэгжийн хэрэглэх цахилгаан эрчим хүчний тарифт өөрчлөлт орж, нэмэгдсэн.

- Гэр хорооллын иргэд халаалт, дулааны асуудлыг цахилгаанаар шийдвэрлэх явдал нэмэгдсэн болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр хэрэглэгчдийн хэрэглэсэн цахилгааны төлбөрт хөнгөлөлт үзүүлсэн зэрэг болно.

Нийт зардлын гүйцэтгэл 14,816.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,588.0 сая төгрөг буюу 12.0 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Үүнд дараах хүчин зүйлс нөлөөлжээ.

1. Хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдсэнээс түгээлтэнд худалдаж авсан цахилгаан эрчим хүчний нийт өртөг 9,974.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь өмнөх оноос 9215.7 мян.кВтц буюу 1,349.6 сая төгрөг, төлөвлөгөөнөөс 5362.4 мян.кВтц буюу 833.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь компанийн нийт зардлын 67.3 хувь, алдагдлын 85.0 хувийг тус тус эзэлж байна.
2. Дэлхийн болон хөрш орнууд, манай орны эдийн засагт үүссэн коронавирусын нөхцөл байдлаас шалтгаалсан хилийн хязгаарлалт, дайн байлдаан, валютын ханшийн өөрчлөлт, инфляци, бараа материалын үнийн өсөлт, шугамын гэмтэл засвар зэрэг шалтгааны улмаас зарим төрлийн зардлууд төлөвлөсөн хэмжээнээс хэтэрсэн байна. Тухайлбал: 2022 онд шатахуун, сэлбэг хэрэгсэл, урсгал засвар, нийгмийн даатгалын шимтгэл, албан томилолт, хөдөлмөр хамгааллын зардал, ус дулааны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, удирдлага, борлуулалт маркетингийн зардал зэрэг зардлууд төлөвлөснөөс хэтэрчээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, ТЗБАХ-ийн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 31 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 786.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 1,251.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 764.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүний 85.0 хувийг худалдаж авсан цахилгаан эрчим хүчний өртөг, үлдсэн 15.0 хувийг үйл ажиллагааны алдагдал эзэлж байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Ц.Мөнхтуяа, Б.Нэргүй нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Б.Мядагмаа хийж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл эрчим хүч ХХК нь 2022 оны санхүүгийн тайлангаа 2023 оны оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 1/48 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 13,201.2 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 264.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага дэд захирлын орон тоо болон чиг үүрэг давхардсан нэг орон тоог цомхотгох, гүйцэтгэх захирал аймгийн төвд автомашин унахгүй байх арга хэмжээ авсан байна.

Энэ хуулийн хүрээнд дэд захирлын орон тоо болон чиг үүрэг давхардсан орон тоог цомхотгосноор 18.8 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 заалтаар хориглосон “ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал,”-д 0.5 сая төгрөг, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 заалтыг зөрчиж баяр ёслол тэмдэглэхэд 4.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 заалтад заасан Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй асуудалд зөвлөмж хүргүүлсэн ба тайлангийн 4.4.1 хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй 0.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.7 сая төгрөгийн зөрчилд албан шаарлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд 2022 онд нийт 148 мэдээлэл оруулахаас 3 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй, тайлант хугацаанд мэдээлэх 145 мэдээллээс 136 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 4 мэдээллийг хугацаа хоцроосон, 5 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 заалт “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” 6 дугаар зүйлийн 6.1.3 заалт “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;”, 6.1.6 заалт “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”, 6.4.6 заалт “худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн;”-г мэдээлэх заалтуудтай тус тус нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах, цаашид алдаа зөрчлийг давтахгүй байх зөвлөмжийг өгөхөөр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Компанийн их засвар, хөрөнгө оруулалт, ТЗБАХ-ын зардлаар 222.6 сая төгрөгийн 2 автомашин худалдаж авахдаа ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 3.4 заалтад заасан тээврийн хэрэгсэл худалдан авах тухай бүрд зөвшөөрөл авах заалтыг хэрэгжүүлээгүй, зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгсэл худалдаж авсан нь “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах, аймгийн ОНӨГ-аас зөвшөөрөл авсны үндсэн дээр тээврийн хэрэгсэл худалдаж авч байх зөвлөмжийг өгөхөөр шийдвэрлэв.

Эрчим хүчний салбарын хамтын хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 3.14 заалт, Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн хамтын гэрээний 3 дугаар зүйлийн 3.9 заалтад эрчим хүчний тэргүүний ажилтанд сар бүр 10 мянган төгрөгийн нэмэгдэл урамшуулал олгохоор заасны дагуу жил бүрийн төсөвт төсөвлөн, тэргүүний ажилтан цол, тэмдэгтэй ажилтанд 6.8 сая төгрөгийн урамшуулал олгосон нь Эрчим хүчний сайдын 2016 оны 97 дугаар тушаал “Журам батлах тухай “-ын 1 дүгээр хавсралтын 5.3 заалтад салбарын тэргүүний ажилтан цол тэмдгийг авахад нэг удаа мөнгөн урамшуулал олгох заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хамтын гэрээ, хэлэлцээрийн заалт нь салбарын сайдын тушаалын заалттай нийцэхгүй байх тул үр ашиггүй зардлыг зогсоох, хамтын гэрээг хууль эрх зүйд нийцүүлэх зөвлөмжийг өгөхөөр шийдвэрлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудитыг хэрэгжүүлсэн бөгөөд нягтлан бодох бүртгэлийн дансны бичилттэй холбоотой 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	10.9	3	10.9	100.0
Нийт дүн	3	10.9	3	10.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ өнгөрсөн оноос 5,362.4, батлагдсан төлөвлөгөөнөөс 9,215.7 мян.кВтц-аар, худалдаж авсан цахилгаан эрчим хүчний өртөг өнгөрсөн оноос 833.2 сая төгрөг, батлагдсан төлөвлөгөөнөөс 1,349.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь компанийн бизнес төлөвлөгөө, зорилтот түвшний биелэлтэд нөлөөлсөн байх тул цаашид компанийн зорилтот түвшнийг төлөвлөх, хянах, батлах түвшинд холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтан анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 294.8 сая төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад 294.8 сая төгрөгийн 2 алдааг залруулсан болно.

Аудитын явцад дараах алдааг залруулсан. Үүнд:

- Иргэн, аж ахуйн нэгжид техникийн нөхцөл олгохтой холбоотой 12.3 сая төгрөгийн орлого болон авлагыг бүртгээгүй байсныг аудитын явцад залруулж бүртгэсэн.
- Тайлант онд худалдан авалт хийсэн 8 харилцагч байгууллагын 282.5 сая төгрөгийн зарлагын гүйлгээг татварын цахим системд э-баримт шивээгүй хийсэн байсныг аудитын явцад нөхөн шивүүлж алдааг залруулсан болно.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 494.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 11.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 243.1 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 239.9 сая төгрөгийн 7 зөвлөмж өгсөн.

Үүнээс нийцлийн аудиттай холбоотой буюу Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Эрчим хүчний сайдын тушаалын биелэлттэй холбоотой асуудлаар 0.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 4.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, 229.4 сая төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 заалтаар хориглосон “ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал;”-д 0.5 сая төгрөгийг зарцуулсан нь “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул төлбөрийн акт тогтоов.

2. Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2022 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 01/383 тоот албан бичгээр Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ой, Нутгийн өөрөө удирдах байгууллагын 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд санхүүгийн дэмжлэг хүссэнийг компанийн ТУЗ-ийн 2022 оны 12 сарын 15-ний өдрийн хуралдааны 11 дүгээр тогтоолоор баталж, Хөвсгөл Бренд Экспо ХХК-д шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 заалтад “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” заалтыг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд Төсвийн тухай хуулийг зөрчиж, ойн арга хэмжээнд дэмжлэг болгон өгсөн 11.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөгөөр батлагдсан үйл ажиллагааны зардлыг 238.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” заалт, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд төлөвлөгөөт зардал хэтрүүлсэн зөрчлийг таслан зогсоож, компанийн зорилтот түвшнийг хангаж ажиллах, төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах албан шаардлага өглөө.

2. Баяр ёслолын зардалд 4.7 сая төгрөгийг компанийн бизнес төлөвлөгөөнд төлөвлөн батлуулж, зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 “хуулиар зөвшөөрөөгүй бусад.” зардлыг санхүүжүүлэхийг хориглоно заалт, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Иймд баяр ёслолын үйл ажиллагаанд компаниас мөнгөн хөрөнгө зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр тушаалын дагуу санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланг бэлтгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах,” заалт, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланг бэлтгэж, санхүүгийн тайланд үр дүнг тусгах.

2. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас ажлаас халагдаж, шүүхийн шийдвэрээр ажилд эргүүлэн тогтоосон 2 ажилтны цалин, шимтгэл 10.3 сая төгрөгийг компаниас олгож, олгосон дүнгээр авлага үүсгэж бүртгэсэн, уг авлагыг барагдуулж, учирсан хохирлыг төлүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” заалт, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Буруутай албан тушаалтнаар төлбөрийг төлүүлж, авлагыг барагдуулах.

3. Урт хугацаат өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Урт хугацаат өр төлбөр дансанд 2007 онд Сангийн яам, Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн хооронд байгуулсан OL-3503MOG-07 тоот дамжуулан зээлдүүлэх 1,008.5 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өглөг бүртгэлтэй, зээлийн үндсэн төлбөрийг хуваарийн дагуу төлж, гэрээний үүргийг биелүүлээгүй байгаа нь компанийн цаашдын үйл ажиллагаанд хүндрэл учруулах эрсдэлтэй, Өрийн удирдлагын тухай хуулийн 31.3.2 заалтад заасан эцсийн зээлдэгч “дамжуулан зээлдүүлэх зээлийн үндсэн, хүүгийн болон бусад төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөх;” үүрэгтэй гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дамжуулан зээлдүүлэх урт хугацаат зээлийн төлбөрийг хэсэгчлэн төлөх дүнг бизнес төлөвлөгөөнд тусгаж, холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулах.

4. Ажиллагсдын мөнгөн урамшуулалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамтын хэлэлцээр, Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн хамтын гэрээнд салбарын тэргүүний ажилтан цол тэмдэгтэй ажилтнуудад жил бүр мөнгөн урамшуулал олгохоор заасны дагуу компанийн бизнес төлөвлөгөөнд тусган, батлуулж 6.8 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Эрчим хүчний сайдын 2016 оны 97 дугаар тушаал “Журам батлах тухай”-ын 1 дүгээр хавсралтын 5.3 заалтад салбарын тэргүүний ажилтан цол тэмдгийг авахад нэг удаа мөнгөн урамшуулал олгох заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрчим хүчний сайдын 2016 оны 97 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шинээр шагнуулсан ажиллагсдад нэг удаа мөнгөн урамшуулал олгож байх, хамтын гэрээ, хэлэлцээрийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэх.

5. ОНӨГ-ын зөвшөөрөлгүй автомашин худалдаж авсан асуудал.

Илрүүлэлт: Компанийн их засвар, хөрөнгө оруулалт, ТЗБАХ зардлаар 2 автомашин худалдаж авсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 3.4 заалтад заасан тээврийн хэрэгсэл худалдан авах тухай бүрд зөвшөөрөл авна гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөлгүйгээр хөрөнгө /авто машин/ худалдан авч бэлтгэхгүй байх.

6. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт техникийн нөхцөл болон үйл ажиллагааны бусад орлогын бүртгэл, найдваргүй авлагын нөөц байгуулах хувь хэмжээ, татварын болон санхүүгийн тайлангийн зөрүүг зохицуулах үзүүлэлтүүд зэргийг тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;” заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн шинэчлэх.

7. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 145 мэдээлэл оруулахаас 4 мэдээлэл хугацаа хоцроосон, 5 мэдээллийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 заалт “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” 6 дугаар зүйлийн 6.1.3 заалт “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;”, 6.1.6 заалт “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”, 6.4.6 заалт “худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн;”-г мэдээлэх заалтуудтай тус тус нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Иргэн, аж ахуйн нэгжид техникийн нөхцөл олгохтой холбоотой 12.3 сая төгрөгийн орлого болон авлагыг бүртгээгүй орхигдуулсан.	1	12.3	1	12.3			1	12.3				
Э-баримт шивэгдээгүй зарлагын гүйлгээг хийсэн.	1	282.5	1	282.5			1	282.5				
Дүн	2	294.8	2	294.8			2	294.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланг бэлтгээгүй.	1	-					1	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд бүрэн нийцээгүй	1	-					1	-
Дамжуулан зээлдүүлэх урт хугацаат зээлийн үндсэн төлбөрийг барагдуулаагүй	1	-					1	-
Нутгийн өөрөө удирдах байгууллагын 30 жилийн ойн зардалд хандив өгсөн.	1	11.0	1	11.0				
Компанийн зорилтот түвшин, бизнес төлөвлөгөө биелээгүй	1	238.4			1	238.4		
Албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлын авлагыг барагдуулаагүй.	1	10.5					1	10.5
Дүн	6	259.9	1	11.0	1	238.4	4	10.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд мэдээлэх 145 мэдээллээс 136 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 4 мэдээллийг хугацаа хоцроосон, 5 мэдээллийг мэдээлээгүй	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ОНӨГ-ын зөвшөөрөлгүй автомашин худалдаж авсан.	1	222.6					1	222.6
Ээлжийн амралтаар нутаг явах зардал гаргасан нь Төрийн хэмнэлтийн хуулийг зөрчсөн.	1	0.5	1	0.5				
Баяр ёслолын үйл ажиллагаанд зардал гаргасан.	1	4.7	1	0.5	1	4.7		
Салбарын тэргүүний ажилтан цол тэмдэгтэй ажиллагсдад урамшуулал олгосон.	1	6.8					1	6.8
Дүн	4	234.6	1	0.5	1	4.7	2	229.4
Нийт дүн	5	234.6	1	0.5	1	4.7	3	229.4



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

№ 57/АХСЭЦО439/ХХА-2023/09
/НА-СТА-ОНА

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөнд баяр ёслол тэмдэглэхтэй холбоотой зардлуудыг төлөвлөж, батлуулан 4,685,700.00 (дөрвөн сая зургаан зуун наян таван мянга долоон зуу)-н төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 “хуулиар зөвшөөрөөгүй бусад” заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно” гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Компанийн бизнес төлөвлөгөөнд баяр ёслолын зардлыг төлөвлөж, батлуулахгүй байх, баяр ёслол тэмдэглэхэд мөнгөн хөрөнгө зарцуулсан зөрчлийг таслан зогсоож ажиллах, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
2. Цаашид гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн гүйцэтгэх захирал З.Бадрал, ерөнхий нягтлан бодогч Д.Бат-Оргил нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Б.ДАВААНЫМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

№ 58/АЭЭ60439/ХӨА-2023/09
/НА-ЛТА-011А

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Хөвсгөл эрчим хүч” ХХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөгөөр батлагдсан зардлыг 238,380,430.00 (хоёр зуун гучин найман сая гурван зуун наян мянга дөрвөн зуун гучин) төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;” заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журам”-ын 4.2.1.5-т “төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн” гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Компанийн бизнес төлөвлөгөө, зорилтот түвшний төлөвлөлтийг үндэслэлтэй хийж батлуулах, гүйцэтгэлд тухай бүрд нь хяналт тавьж, төлөвлөгөөт зардлыг хэтрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
2. Цаашид гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн гүйцэтгэх захирал З.Бадрал, ерөнхий нягтлан бодогч Д.Бат-Оргил нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Б.ДАВААНЯМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2023 оны 03 сарын 15 өдөр

№ 47/АЭЭБ/0439/ХАА-2023/09
/АА-СТА-0111

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Хөвсгөл эрчим хүч" ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Нутгийн өөрөө удирдах байгууллагын 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд санхүүгийн дэмжлэг хүссэнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 сарын 15-ний өдрийн хуралдааны 11 дүгээр тогтоолоор баталж, "Хөвсгөл Бренд Экспо" ХХК-д 11,000,000.00 (арван нэгэн сая) төгрөг шилжүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 дахь "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориалоно" заалтыг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.1. "төрийн өмч, хөрөнгийг үндэслэлгүйгээр бусдад хандивласан, үнэ төлбөргүй шилжүүлсэн" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Нутгийн өөрөө удирдах байгууллагын 30 жилийн ойд дэмжлэг болгон шилжүүлсэн 11,000,000.00 (арван нэгэн сая) төгрөгийг Хөвсгөл Бренд экспо ХХК-аас буцаан авч, аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн гүйцэтгэх захирал З.Бадрал, ерөнхий нягтлан бодогч Д.Бат-Оргил нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Б.ДАВААНЯМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2023 оны 03 сарын 15 өдөр

№ 18/АХХ60439/ХАА-2023/09
/НА-СТА-011А

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Хөвсгөл эрчим хүч” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн ажилтан Л.Дариймаад ээлжийн амралтаараа төрсөн нутагт амрах ирэх, очих унааны зардлыг 538,000.00 (таван зуун гучин найман мянга)-н төгрөгөөр тооцож олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно” 12.1.2. дахь “ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал;” гэсэн заалтыг зөрчиж, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8. “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн

ТОГТООХ нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 заалтыг зөрчиж, ээлжийн амралтаар нутаг явж амрах замын зардалд олгосон 538,000.00 (таван зуун гучин найман мянга)-н төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн гүйцэтгэх захирал З.Бадрал, ерөнхий нягтлан бодогч Д.Бат-Оргил нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Б.ДАВААНЯМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043